

НУУЦЫГ ХАДГАЛАХ ЖУРАМ

1. ЗОРИЛГО

1.1. Энэхүү журмын зорилго нь Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын дэргэдэх допингийн Давж заалдах комисс /цаашид “Комисс гэх/-ын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон хувь хүний нууц, байгууллагын нууц, төрийн болон албаны нууц мэдээллийг хадгалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Комиссын хэрэгт оролцогсод. Үүнд: Бүрэлдэхүүн даргалагч, Бүрэлдэхүүний гишүүд, Ажлын албаны дарга, Нарийн бичгийн дарга, нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, гэрч, зөвлөх, шинжээч, өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хэлмэрч, орчуулагч нар.

3. ХАРИУЦЛАГА

3.1. Ажлын албаны дарга, Нарийн бичгийн дарга нар нь Комисст хамаарах бүх мэдээ, мэдээлэл, түүний эх үүсвэрийг хадгалж, хамгаалах бүх ажлыг хариуцна.

4. НУУЦЫН ХАМААРАЛ

4.1. Энэ журмын “нууц” хэмээх ойлголтод дараах мэдээлэл, биет болон биет бус зүйлсийг хамруулна:

- 4.1.1. Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц,
- 4.1.2. Комиссын хавтаст хэргийн материал,
- 4.1.3. Комиссын шийдвэр,
- 4.1.4. Комиссын урамшуулал,
- 4.1.5. Комиссын нэхэмжлэлийг хүлээн авсан бүртгэл,
- 4.1.6. Дээрх бичиг баримтуудын электрон хувилбарууд,
- 4.1.7. Төрийн нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль болон энэ журамд заасан нууцууд,
- 4.1.8. Хэргийн оролцогч нарын нууцлахыг хүссэн бусад мэдээллүүд.

5. НУУЦЛАЛААС ГАДУУРХ МЭДЭЭЛЭЛ

5.1. Комиссын хэрэг хянан шийдвэрлэхээс бусад мэдээлэл, сургалт, семинар, олон нийтийн биеийн тамир, спортод уриалсан үйл ажиллагааны мэдээлэл

6. НУУЦТАЙ ТАНИЛЦАХ, НУУЦЫГ ИЛ БОЛГОХ

6.1. Хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, тэдгээрийн ажилтан нь эрх олгосон хянан шалгах бүрэн эрх, чиг үүргийнхээ дагуу Комиссын хадгалж буй нууцтай танилцаж болно.

6.2. Комиссын хамгаалалтанд буй нууцтай албан үүргийнхээ дагуу танилцсан, эсхүл олж мэдсэн этгээд нууцыг зөвхөн хууль тогтоомжид заасан үндэслэл, журамд нийцүүлэн ашиглах бөгөөд бусдад задруулахыг хориглоно.

6.3. Нууц мэдээллийг эзэмшигчийн бичгээр гаргасан зөвшөөрлөөр эсвэл хуульд заасан шаардлагаар ил болгож болно.

6.4. Нууц мэдээллийг ил болгохыг хуулиар шаардсан, эсвэл хэлэлцээрээр тохиролцсон үед холбогдох мэдээллийг хуулиар хориогүй бол талуудад мэдэгдэнэ.

7. НУУЦЫГ ЗАДРУУЛАХГҮЙ БАЙХ БАТАЛГАА

7.1. Нууц задруулахгүй байх баталгаа нь энэхүү журмын хавсралт бөгөөд салшгүй хэсэг байна.

НУУЦЫГ ХАМГААЛАХ МЭДЭГДЭЛ

Огноо

Улаанбаатар хот

Энэхүү БАТАЛГААНД допингийн Давж заалдах комисст шийдвэрлэгдэж хэрэгт оролцож байгаа бүх хүмүүс гарын үсэг зурна.

Би допингийн Давж заалдах комиссын /цаашид “Комисс” гэх/, нууцлалын шаардлагыг бүрэн ойлгосны үндсэн дээр энэхүү БАТАЛГААГ албан ёсоор хийж байна. Үүнд:

Миний бие хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад олж авсан хүний хувийн, төрийн болон албаны нууц мэдээллийг нууцад нэвтрэх эрхгүй болон энэхүү нууц байдлын мэдэгдэлд гарын үсэг зураагүй хэн бүхэнд дамжуулахгүй гэдгээ амлаж байна.

Би Комиссын нууцлалын шаардлагыг бүрэн биелүүлж, шударгаар ажиллаж, нууцыг чанд хадгалж, Давж заалдах комиссын нэр төрийг ухамсартайгаар хамгаалах болно. Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй аливаа үйл ажиллагаанд татагдан орохгүй.

Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад олж авсан хэрэгт оролцогсдын талаарх нууц мэдээллийг хадгалж, тухайн мэдээлэл нь хуулийн дагуу ил тод болсон буюу хэвлэлд нийтлэгдсэнээс бусад тохиолдолд хэрэгт оролцогчдын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч талд мэдээллийг задруулахгүй гэдгээ амлаж байна.

Хэрэв би өөрт танилцуулагдсан төрийн болон албаны нууцыг задруулсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны хариуцлага хүлээхийг ухамсарлаж байна.

Даргалагч:

Бүрэлдэхүүн:

Бүрэлдэхүүн:

Ажлын албаны дарга:

Нарийн бичгийн дарга:

Нэхэмжлэгч:

Өмгөөлөгч болон

итгэмжлэгдсэн төлөөлөгч

Хариуцагч:

Өмгөөлөгч болон

итгэмжлэгдсэн төлөөлөгч

Хариуцагч:

Өмгөөлөгч болон

итгэмжлэгдсэн төлөөлөгч

Хариуцагч:

Өмгөөлөгч болон

итгэмжлэгдсэн төлөөлөгч